

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРЭМ – 331

ЗОРЧИГЧДЫН БҮРТГЭЛ

331.1. Зорилго.....	2
331.3. Тодорхойлолт.....	2
331.5. Дүрмийн үйлчлэх хүрээ.....	2
331.7. Бүртгэлд тавигдах шаардлага.....	3
331.9. Бүртгэлийг бүрдүүлэх журам.....	3
331.11. Нисэхийн осол аюулын талаарх мэдээллийг дамжуулах.....	3
331.13. Бүртгэл мэдээллийг дамжуулах.....	3
331.15. Гадаад улсын хуультай үл нийцэх.....	3

Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын
2010 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 160 дугаар
тушаалын 24 дүгээр хавсралт

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРЭМ - 331

ЗОРЧИГЧДЫН БҮРТГЭЛ

331.1 Зорилго

(а) Энэ дүрмийн зорилго нь нислэг үйлдэж буй агаарын хөлөгт осол аюул тулгарсан үед эрх бүхий байгууллага, этгээдийг зорчигчдын талаарх шаардлагатай мэдээллээр хангахад оршино.

331.3 Тодорхойлолт

Агаарын хөлгийг булаан авах гэж хүч хэрэглэх буюу айлган сүрдүүлэх аливаа хэлбэрээр нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн нисэх багийн үйл ажиллагаанд хууль бусаар хөндлөнгөөс оролцох буюу нисэх багийн үйл ажиллагааг хяналтанд авахыг;

Бүтэн нэр гэж зорчигчийн мэдээлсэн бүтэн овог, нэрийг

Зорчигч гэж агаарын хөлгөөр зорчихоор агаарын тээвэрлэгчтэй гэрээ байгуулсан этгээд болон:

(а) өөр тээвэрлэгчийн нислэгнээс шилжүүлэн суулгасан этгээд, нялх хүүхэд, нисэх багийн бүхээг дэх ажиглагчийн суудал эзэлж буй этгээдийг тээврийн хөлс төлсөн эсэхээс үл хамааран; мөн

(б) тухайн нислэгийн үед албан үүргээ гүйцэтгээгүй боловч агаарын хөлгөөр зорчиж байгаа агаарын тээвэрлэгчийн ажилтныг.

Зорчигчдын бүртгэл гэж тухайн агаарын хөлгөөр тээвэрлүүлж байгаа зорчигчдын бүтэн нэр, асрамж шаардлагатай зорчигчийн бүтэн нэр, суудлын дугаар, тээшний талаарх мэдээллийг агуулсан жагсаалтыг;

Нисэхийн осол аюул гэж:

(а) нислэгийн үйл ажиллагааны аль нэг үе шатанд агаарын хөлөг дэлбэрэх, гал гарах болон хорлон сүйтгэх ажиллагаанд өртөх, осолдох тохиолдолд агаарын хөлгөөр зорчиж байсан аливаа этгээд хүндээр гэмтэх, нас барахыг, эсхүл

(б) агаарын хөлөг сураггүй болох, эсхүл

(в) агаарын хөлөг хөндлөнгийн хууль бус үйлдэлд өртсөн тохиолдлыг.

331.5 Дүрмийн үйлчлэх хүрээ

(а) Энэ дүрэм нь Монгол Улсад бүртгэлтэй агаарын тээвэрлэгч болон гадаадын агаарын тээвэрлэгчийн Монгол Улсад гүйцэтгэх, мөн Монгол Улсаас эхлэлтэй зорчигч тээврийн бүх нислэгт хамаарна.

331.7 Бүртгэлд тавигдах шаардлага

(а) Тээвэрлэгч нь:

- 1/ зорчигч тус бүрийг орон нутгийн нислэгт иргэний үнэмлэх, олон улсын нислэгт тухайн улсад зорчиход тавигдах шаардлагыг хангасан гадаад паспортыг нь үндэслэн бүтэн нэрээр нь бүртгэх бөгөөд бүртгэлд хамрагдаагүй этгээдийг агаарын хөлөгт оруулахгүй.
- 2/ зорчигч нь Монгол Улсын иргэн бол хувийн болон бусад холбоо тогтоох утасны дугаарыг бүртгэлд оруулна.
- 3/ бүрдүүлсэн мэдээллийг зорчигчийн тийзний хүчинтэй хугацаа дуусах хүртэл хадгална.

(б) Агаарын тээвэрлэгч нь энэ зүйлийн (а)-г дагаж мөрдөж буйг бататгах үүрэгтэй.

331.9 Бүртгэлийг бүрдүүлэх журам

(а) Агаарын тээвэрлэгч нь дараах тохиолдлуудад хамааралтайгаар зохих мэдээллийг бүртгэж, цуглуулах, хадгалах, дамжуулах аливаа аргачлал, журмыг мөрдөнө:

- 1/ тухайн нислэгээр зорчих зорчигч бүрийн талаарх мэдээллийг агаарын хөлөгт суухаас нь өмнө бүрдүүлсэн байна;
- 2/ тухайн нислэгийн хувьд, нислэг гүйцэтгэгдэж, зорчигчид агаарын хөлгөөс буух хүртэл хугацаанд мэдээллийг хадгална;
- 3/ энэ дүрмийн 331.7-ийн (а)-гийн 2/-ын дагуу бүртгэлд тусгагдсан, холбоо барих мэдээллийг нууцлах ба шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагад дамжуулна;
- 4/ бүртгэлд тусгагдсан мэдээллийг энэ дүрэмд зааснаас өөр зорилгоор ашиглаж болохгүй.

331.11 Нисэхийн осол аюулын талаарх мэдээллийг дамжуулах

(а) Тээвэрлэгч нь өөрийн агаарын хөлөгт аюул осол тулгарсан талаар мэдсэн даруйдаа ИНЕГ-ын эрх бүхий этгээдэд яаралтай мэдэгдэнэ.

(б) Тээвэрлэгч нь энэ дүрмийн 331.9-ийн дагуу бүрдүүлсэн мэдээллийг аюул ослын талаар мэдсэнээс хойш 3 цагийн дотор ИНЕГ-т ирүүлнэ.

331.13 Бүртгэл мэдээллийг дамжуулах

(а) Тээвэрлэгч нь шаардлагатай тохиолдолд энэ дүрмээр шаардсан зорчигчдын бүртгэл, мэдээллийг эрх бүхий байгууллагад дамжуулах журмыг боловсруулна.

331.15 Гадаад улсын хуультай үл нийцэх

(а) Энэ дүрмээр шаардсан зорчигчдын бүртгэлийг бүрдүүлэх, дамжуулах шаардлага нь нислэг үйлдэх гадаад улсын хуульд нийцэхгүй тохиолдолд тухайн улс руу нислэг үйлдэж эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө энэ талаар ИНЕГ-ын даргад мэдэгдэнэ.

(б) Мэдэгдэлд гадаад улсын холбогдох хуулийн заалтын тайлбар, ишлэлийг хавсаргана.

(в) Энэ дүрэм гадаад улсын хууль дүрэмтэй зөрчилдөж байгаа нь тогтоогдвол ИНЕГ-ын дарга Тээвэрлэгчийг ИНД-11-ийн дагуу энэ дүрмийн шаардлагаас чөлөөлж болно.

